

ТАВАН ТОЛГОЙН 536 ХУВЬЦААГ ЯАВАЛ ДЭЭР ВЭ?

Д. Дотно – МИСС-ийн СУДАЛГААНЫ ШИНЖЭЭЧ

2011-09-26

Хорь гаруй жилийн өмнө хуучин социалист улсууд төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг хувьчилахдаа ард түмэнд эрх тэгш байдалтайгаар хувьцаа олгох нэрийдлээр арилжааны хязгааргүй хувьцаа авах талон тараасан билээ. Гэтэл цөөн тооны хүмүүс л зах зээлийн тухай тодорхой хэмжээний ойлголттой, хувьцааны үнэ



цэнийг мэддэг байжээ. Эдгээр хүмүүс жирийн иргэдээс талонг тухайн үеийн зах зээлийн үнээр худалдан авч улмаар хувьчилалын дараа их хэмжээний хувьцааг хямдханаар авсан байна. Тун удалгүй эдгээр хувьцааны үнэ маш өндөр болж өссөн учираас хэдхэн жилийн дотор тэд “олигархууд” болж чаджээ. Жишээлбэл Оросын алдарт олигарх Михаил Ходорковский ЮКОС компанийг 1996 онд 300 сая ам.доллараар худалдаж авсан нь 2003 онд 27 тэрбум ам.долларын үнэтэй болсон байжээ.

Энэ үйл явц 90-ээд оны үед Монголд бас өрнөсөн нь нууц биш ч дахин давтагдах аюул тулгараад байна. Таван Толгойн хувьцаа тун удалгүй ард түмэнд өнөөх талон шиг тараагдах гэж байгаа сурагтай ч Эрдэнэс Таван Толгой компаний тухай хэрэгтэй мэдлэгтэй хүн хэд байгаа билээ? Монголын ард түмний ихэнхид нь хувьцаа, санхүүгийн зах зээлийн тухай анхан шатны ойлголт, туршлага байхгүйгээс гадна уул уурхайн салбар ба компаниудын тухай нарийн мэдээлэл бүр ч олддоггүй билээ. Харин гадаадын хөрөнгө оруулагчид болон цөөхөн хэдэн монголчуудад мэдээлэл олж авах боломж, эрх мэдэл нь байна. Иймээс мэдээллийн тэгш бус байдал үүсэх нь тодорхой болоод байна.



Дашрамд хэлэхэд, энэ “Мэдээллийн Тэгш Бус Байдал” гэдэг нэр томъёо нь эдийн засгийн онолын чухал сэдэв төдийгүй энэ нэр томъёог тодорхойлсоноороо Ж. Акерлоф, Ж. Стиглиц нарын эдийн засагчид Нобелийн шагналыг хүртэл авч байжээ. Энэхүү онолыг анх тодорхойлоход “Лимоны Зах Зээл” хэмээх нийтлэлдээ хуучин машины зах зээлийг жишээ болгосон нь өнөөдөр ч бодит хэвээр. Гол санаа нь гэвэл хуучин машины чанарын асуудлыг худалдагч нар нь нууцалж хүн луйвардаж ашиг хонжоо олох боломжтой учираас хүмүүс цөхрөхдөө ямар ч хуучин машиныг сайн машины үнээр авахгүйд хүрдэг тухай юм. Өөрөөр хэлвэл мэдээллийн тэгш бус байдал нь зах зээлд сөрөг

нөлөөтэй төдийгүй зах зээлд оролцож буй хүмүүсийг эрх тэгш өрсөлдөх боломжгүй болгодог юм.

Тэгвэл Эрдэнэс Таван Толгой компаний хувьцааг яах вэ? Энэ компани болон түүхий эдийн зах зээлийн тухай ямар нэгэн мэдээлэл нууцлагдаж олон нийтийн сонорт хүрэхгүй байгаа болов уу? Ямар ч байсан 5 жил юм уу, тодорхой хугацаанд арилжиж болохгүй гэсэн яриа гарч байна. Энэ хязгаарлал бол Монголын засгийн газар социалист системийн задралаас сурсан сургамжийн илрэл юм.

Ядуурал, ажилгүйдэл өргөн тархсан өнөө үед зарим иргэдэд үнэгүй ирсэн хувьцааг хадгалж суух нь өнөө маргаашийн хоолыг залгуулахаас чухал санагдахгүй нь мэдээж. Харин хэцүү амьдралтай хүмүүс түрүүлж хувьцаагаа зарахыг мэдсэн цөөхөн “мэдлэгтэй хэд” нь хямдханаар эдгээр хувьцааг хуримтлуулахаар зэхэж байгаа нь лавтай. Таван Толгойн хувьцаа гарах болоо ч үгүй байтал иргэд заасан үнээс хэд дахин өндөр үнэ нэрлэж гадаад дотоодын хөрөнгийн сангуудад зарах гэсэн оролдлого ч гарч байна. Бид бүгд Таван Толгойд чухам ямар их нөөц байгаа, хэр ихийг нь ашиглаж болох, төслийг хэрэгжүүлэх компаний тогтолцоо, үйл ажиллагааны чанарын талаар гаднаас нь л харж таамаглаж байхад Эрдэнэс Таван Толгойн төсөлтэй ойрхон ажиллаж байгаа хэсэг бүлэг хүмүүс биднээс ихийг мэдэж л байгаа нь лавтай.

Ямар ч аж ахуйн нэгжийн бүх үнэнийг олон нийтэд нэг бүрчилэн танилцуулах боломжгүй байдаг ч ямартай ч ард түмэн хувьцаагаа зарахаар, эсвэл хадгалахаар шийдэхээсээ өмнө яарахгүй байх хэрэгтэй. Бүх юм нь зах зээлжсэн, хөгжингүй орнуудад хүртэл мэдээллийн тэгш бус байдлаас болж хүмүүс хохирч, мэхлүүлж байдаг. Иймээс Эрдэнэс Таван Толгойн хувьцаа биржүүд дээр арилжаалагдаа гэхэд зарах боломж олондонт хямд үнээр зараад хэрэггүй биз. Тэгээд ч иргэдэд өгөх хувьцаа нь биржүүд дээр арилжаалагдах хувьцаануудтай нь адил төрлийнх байх эсэх нь одоохондоо тодорхойгүй бөгөөд хэрэв нэг төрөл нь нөгөөхөөсөө давуу эрхтэй бол иргэдийн хувьцааны зах зээлийн үнийг тодорхойлоход улам хэцүү болгох юм.

Ард түмэн өөрсдийгөө мэргэжлийн хөрөнгө оруулагч нар, биржийн дамын худалдаачдаас хамгаалах цорын ганц арга бол мэдлэгтэй болох явдал юм. Одооноос эхэлж хөрөнгийн зах зээлийн түүх, тогтолцоо, эрсдэл, хэрэглээний талаар төдийгүй эдийн засгийн ерөнхий байдалтай ч танилцаж, тодорхой компаниудын талаар нарийн мэдлэг хуримтлуулах хэрэгтэй. Хувьцаагаа хадгалсан тохиолдолд Таван Толгой ашиг олж эхэлснээс хойш ногдол ашигаар нь дамжин байнгын орлоготой болохыг бас бүү мартаарай. Ер нь бол Хятад хөгжиж л байвал, дэлхийн нүүрсний эрэлт хэрэгцээ өсч л байвал нүүрсний уурхай ашигтай байх боловч хувьцааны үнэ нь уурхай ашиглалтанд

байх жилүүдэд хувьцааны эзэнд ирэх ногдол ашигаа төлөөлөх ёстойг санаж хувьцааны үнийн өсөлт, бууралтын нарийн учрыг ойлгож, зөв тооцоолж яваарай.